



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

664.	Шүүгчдийг сэлгэн ажиллуулах тухай	Дугаар 195	2465
665.	Албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Дугаар 201	2467
666.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 203	2468
667.	Шүүхийн сахилгын хорооны дарга томилох тухай	Дугаар 205	2468
668.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 206	2469

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

669.	Хоолны зардлын дундаж норматив батлах тухай	Дугаар 106	2469
670.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 109	2471

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр  
Улаанбаатар хот

Дугаар 195

#### Шүүгчдийг сэлгэн ажиллуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1,



Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Доржсүрэнгийн Алтаннавчийг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Батбаярын Мөнхбаярыг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Пүрэвийн Туяаг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Ганзоригийн Билгүүнийг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Жавзмаагийн Байгалмааг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд, Сүрэнхүүгийн Аюушжавыг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Рагчаагийн Үүрийнтуяаг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд, Бямбаюугийн Цолмонгэрэлийг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Ягнайжавыг Туулыг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд, Амаржаргалын Алтанхуягийг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Бямбаюугийн Цолмонг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд, Өлзийн Уянгыг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Намдагсүрэнгийн Батчимэгийг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Тогтохын Гандиймааг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан



тушаалаас Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Жуумаагийн Кульданаг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Намсрайн Нарангэрэлийг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Хашхүүгийн Одбаярыг Дорнод аймгийн сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Гэрэлийн Тэгшсуурийг Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Мөнхөөгийн Пүрэвсүрэнг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус сэлгэн ажиллуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2012 оны 11 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар  
хот

### **Албан тушаалын зэрэг дэв олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн аудитийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхий аудитор Аюурын Зангадад Төрийн аудитын тэргүүн түшээ зэрэг олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 11 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 203

Улаанбаатар  
хот

### **Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Зоригтын Түвшинтөгсийг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн, Нямжавын Гэрэлтуяаг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Бүдрагчаагийн Отгонбямбыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Батжаргалын Дэлгэрцэцэгийг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Цэгмидийн Дайрийжавыг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 12 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар  
хот

### **Шүүхийн сахилгын хорооны дарга томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Оросоо овогтой Зандрааг Шүүхийн Сахилгын хорооны даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2012 оны 12 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар  
хот

### **Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4-т заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Чойндонгийн Дулмааг Увс аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 106

Улаанбаатар  
хот

### **Хоолны зардлын дундаж норматив батлах тухай**

Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15.1, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай



хуулийн 23.1.1, 23.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 600 (зургаан зуун) төгрөгөөр тогтоосугай.

2. Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 (нэг мянга зургаан зуун тавин) төгрөгөөр, 24 цагаар ажилладаг цэцэрлэг, сувиллын болон тусгай цэцэрлэгт 2400 (хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай.

3. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315 (хоёр мянга гурван зуун арван таван) төгрөгөөр тогтоосугай.

4. Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Сангийн сайд Ч.Улаан болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Хүүхдийн хоолонд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний чанар, илчлэг, шимт бодисын хэмжээ, эрүүл ахуйн шаардлага, орчны ариун цэвэрт тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 45 дугаар тогтоол, “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 85 дугаар тогтоол, “Зардлын дундаж норматив батлах тухай”



Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 342 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**САНГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар  
хот

### **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдөр, тодорхой салбар, байгууллагын ой, зарим ажил, мэргэжлийн ажилтан, ажилчдын өдрийг тохиолдуулан ажилтан, албан хаагчдаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөнгөн шагналаар урамшуулахаар хүсэлт гаргах, хандив, бэлэг, бусад санхүүгийн туслалцаа авах асуудлыг таслан зогсоохыг төсвийн захирагч нарт даалгасугай.

2. Яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн байгууллага, тодорхой салбарын тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэхдээ Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ыг хатуу мөрдөж ажиллахыг Засгийн



газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)  
Утас: 262420, 329612  
Хэвлэлийн хуудас: 0.5  
Индекс: 14003